



**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,  
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2019.12.19 № 01/8920

таний -ны № -т

Г АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН Г  
БОЛОН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН  
НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД

Журмын хэрэгжилтийг  
хангах тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" А/618 дугаар тушаалаар "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ыг шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дээрх тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4531 дугаарт бүртгэсэн бөгөөд 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх болсныг мэдэгдэж байна.

Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалыг хүчингүй болгосон.

Хэрэв байгаль орчинд хортой нөлөөлж, нөхөн сэргээлтийг хийгээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулж, хэрэгжүүлээгүй ажилласан тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтын дагуу хариуцлага тооцохыг мэдэгдэж байна.

Иймд Та бүхэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайланг боловсруулахдаа шинэчлэн баталсан журмыг хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг ханган, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлж, байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах, байгаль орчны удирдлагын тогтолцоо MNS ISO 14001:2016 стандартыг үйл ажиллагаандaa нэвтрүүлж, үүрэг, хариуцлагаа ухамсарлан хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж ажиллахыг анхааруулж байна.

Жич: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал нь Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн <https://www.legalinfo.mn/annex/details/6735?lawid=11024> хаягт тавигдсан байгаа болно.



Н.ЦЭРЭНБАТ

012002